



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/256/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
<a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a>	Утас: 7036-3040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум	Аудитын менежер: Б.Батмөнх
2023 он	Утас: 7036-3036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
	Аудитор: 3.Золбоо
	Утас: 7036-2442 Цахим хаяг: Zolbooz@audit.gov.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Аудитын дүгнэлт	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11-14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
4. Аудитын тайлан	15-17
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	18

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2023-02-24 № 10А-2023/256 НА-СТА-ТДЗ

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн 192,613.0 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 99.4 хувьтай тайлагнагдсан бөгөөд тогтмол зардлыг 3.6 хувиар, хангамж, бараа материалын зардлыг 1.3 хувиар хэмнэснээс голлон шалтгаалж нийт төсөв 0.6 хувиар хэмнэгдсэн байна.

### Аудитын гол асуудал

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 79.3 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, 9.9 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал эзэлж байна.

- 018020062<sup>2</sup>

### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан



Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>10,342,033.0</b>	<b>13,270,826.4</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>709,300.0</b>	<b>3,158,742.4</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	709,300.0	3,150,900.0
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	-	<b>7,842.4</b>
33510	Байгууллагаас авах авлага	-	7,842.4
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>9,632,733.0</b>	<b>10,112,084.0</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>549,376.0</b>	<b>921,100.0</b>
35110	Тусгай зориулалттай материал	549,376.0	476,100.0
35130	Эм боох материал	-	445,000.0
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>9,083,357.0</b>	<b>9,190,984.0</b>
35410	Бичиг хэргийн материал	899,555.0	986,135.0
35420	Аж ахуйн материал	7,132,369.0	7,554,849.0
35440	Түлш, шатах тослох материал	1,051,433.0	650,000.0
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>35,542,206.7</b>	<b>56,215,725.1</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>35,542,206.7</b>	<b>56,215,725.1</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>35,278,206.7</b>	<b>56,070,525.1</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	11,418,795.0	11,418,795.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	(879,187.7)	(1,069,501.0)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	15,000,000.0	15,000,000.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(4,843,750.0)	(6,250,000.0)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	91,954,600.0	46,496,010.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	(78,501,226.6)	(10,440,201.4)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,508,734.0	3,903,446.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,895,758.0)	(3,504,023.5)
39214	Бусад үндсэн хөрөнгө	516,000.0	516,000.0
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>264,000.0</b>	<b>145,200.0</b>
39301	Программ хангамж	792,000.0	792,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(528,000.0)	(646,800.0)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>45,884,239.7</b>	<b>69,486,551.5</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>1,527,000.0</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>1,527,000.0</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	-	<b>1,527,000.0</b>
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	360,000.0
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	-	<b>1,167,000.0</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,167,000.0
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>45,884,239.7</b>	<b>67,959,551.5</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>45,884,239.7</b>	<b>67,959,551.5</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	114,990,139.0	114,990,139.0
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	114,990,139.0	114,990,139.0
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(72,604,968.0)</b>	<b>(50,529,656.2)</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(77,491,576.6)	(72,604,968.0)
51220	Тайлант үеийн үр дүн	4,886,608.7	22,075,311.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,499,068.7	3,499,068.7
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>45,884,239.7</b>	<b>69,486,551.5</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он (төгрөгөөр/)
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>207,801,634.0</b>	<b>265,070,196.0</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>77,039,134.0</b>	<b>142,978,296.0</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>77,039,134.0</b>	<b>142,978,296.0</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>75,942,134.0</b>	<b>112,634,600.0</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	75,942,134.0	112,634,600.0
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,097,000.0	30,343,696.0
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>130,762,500.0</b>	<b>122,091,900.0</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>130,302,500.0</b>	<b>117,991,900.0</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	130,302,500.0	117,991,900.0
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>460,000.0</b>	<b>4,100,000.0</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	460,000.0	4,100,000.0
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>202,915,025.3</b>	<b>242,994,884.2</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>202,915,025.3</b>	<b>242,994,884.2</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>175,301,547.0</b>	<b>205,911,906.5</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>117,802,079.8</b>	<b>134,986,775.2</b>
210101	Үндсэн цалин	84,909,028.1	95,681,722.7
210102	Нэмэгдэл	28,248,551.7	26,418,506.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,644,500.0	6,410,000.0
210104	Урамшуулал	-	6,476,546.3
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>15,293,013.7</b>	<b>16,879,408.6</b>
210201	Тэтгэврийн даатгал	10,581,040.5	11,477,808.6
210202	Тэтгэмжийн даатгал	1,177,993.3	1,350,400.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	942,394.6	1,080,300.0
210204	Ажилгүйдлийн даатгал	235,598.8	270,100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	2,355,986.5	2,700,800.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>16,179,116.0</b>	<b>18,949,478.1</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,486,443.0	1,112,342.1
210302	Түлш, халаалт	5,633,653.0	8,448,126.0
210303	Цэвэр, бохир ус	659,020.0	989,010.0
210304	Байрны түрээс	8,400,000.0	8,400,000.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,560,031.1</b>	<b>8,389,053.0</b>
210401	Бичиг хэрэг	692,790.0	957,500.0
210402	Тээвэр, шатахуун	3,617,570.0	3,920,633.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,997,721.1	2,432,220.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	85,800.0	149,200.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,166,150.0	929,500.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>820,000.0</b>	<b>331,600.0</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	820,000.0	331,600.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>979,500.0</b>	<b>1,623,200.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	860,000.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	105,000.0	-
210604	Урсгал засвар	874,500.0	763,200.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,673,200.0</b>	<b>5,090,200.0</b>
210702	Дотоод албан томилолт	6,673,200.0	5,090,200.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,218,408.0</b>	<b>2,500,844.0</b>
210803	Даатгалын үйлчилгээ	49,500.0	49,500.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,948.0	68,068.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.0	22,000.0

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	253,000.0
210807	Газрын төлбөр	5,160.0	
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,085,800.0	2,108,276.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>8,776,198.3</b>	<b>17,161,347.6</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,140,000.0	5,062,250.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,480,000.0	1,337,800.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,156,198.3	10,761,297.6
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>27,613,478.4</b>	<b>37,082,977.8</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	<b>26,000,000.0</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	26,000,000.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>21,731,400.0</b>	<b>330,000.0</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,911,400.0	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	820,000.0	330,000.0
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>5,882,078.4</b>	<b>10,752,977.8</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,882,078.4	10,752,977.8
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>4,886,608.7</b>	<b>22,075,311.8</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>4,886,608.7</b>	<b>22,075,311.8</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>206,664,334.0</b>	<b>232,329,900.0</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>75,901,834.0</b>	<b>110,238,000.0</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>75,901,834.0</b>	<b>110,238,000.0</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>75,901,834.0</b>	<b>110,238,000.0</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	75,901,834.0	110,238,000.0
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>130,762,500.0</b>	<b>122,091,900.0</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>130,302,500.0</b>	<b>117,991,900.0</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	130,302,500.0	117,991,900.0
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>460,000.0</b>	<b>4,100,000.0</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	460,000.0	4,100,000.0
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>199,314,334.0</b>	<b>230,958,200.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>199,314,334.0</b>	<b>230,958,200.0</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>171,700,855.6</b>	<b>193,875,222.2</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>118,017,356.8</b>	<b>134,993,826.1</b>
210101	Үндсэн цалин	80,430,267.3	95,688,773.7
210102	Нэмэгдэл	32,942,589.5	26,418,506.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,644,500.0	6,410,000.0
210104	Урамшуулал	-	6,476,546.3
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>15,293,013.7</b>	<b>16,880,200.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	10,581,040.5	11,478,600.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,177,993.3	1,350,400.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	942,394.6	1,080,300.0
210204	Ажилгүйдлийн даатгал	235,598.8	270,100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	2,355,986.5	2,700,800.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>16,179,116.0</b>	<b>18,949,478.1</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,486,443.0	1,112,342.1
210302	Түлш, халаалт	5,633,653.0	8,448,126.0
210303	Цэвэр, бохир ус	659,020.0	989,010.0
210304	Байрны түрээс	8,400,000.0	8,400,000.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>9,216,461.1</b>	<b>7,265,900.0</b>

210401	Бичиг хэрэг	1,031,790.0	822,980.0
210402	Тээвэр, шатахуун	3,775,000.0	3,455,200.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,997,721.1	2,072,220.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	85,800.0	149,200.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,326,150.0	766,300.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>820,000.0</b>	<b>776,600.0</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	820,000.0	776,600.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,461,000.0</b>	<b>1,991,000.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	860,000.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	660,000.0	367,800.0
210604	Урсгал засвар	801,000.0	763,200.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,673,200.0</b>	<b>5,090,200.0</b>
210702	Дотоод албан томилолт	6,673,200.0	5,090,200.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>420,708.0</b>	<b>1,312,568.0</b>
210803	Даатгалын үйлчилгээ	49,500.0	49,500.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,948.0	68,068.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.0	22,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	253,000.0
210807	Газрын төлбөр	5,160.0	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	288,100.0	920,000.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,620,000.0</b>	<b>6,615,450.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,140,000.0	5,062,250.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,480,000.0	1,553,200.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>27,613,478.4</b>	<b>37,082,977.8</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	<b>26,000,000.0</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	26,000,000.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>21,731,400.0</b>	<b>330,000.0</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,911,400.0	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	820,000.0	330,000.0
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>5,882,078.4</b>	<b>10,752,977.8</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,882,078.4	10,752,977.8
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>7,350,000.0</b>	<b>1,371,700.0</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>7,350,000.0</b>	<b>1,371,700.0</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>7,350,000.0</b>	<b>1,371,700.0</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>7,350,000.0</b>	<b>1,371,700.0</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,350,000.0	1,371,700.0
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(7,350,000.0)</b>	<b>(1,371,700.0)</b>



## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>1</b>	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>114,990,139.0</b>	<b>3,499,068.7</b>	<b>(77,491,576.6)</b>	<b>40,997,631.0</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	114,990,139.0	3,499,068.7	(77,491,576.6)	40,997,631.0
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	4,886,608.7	4,886,608.7
<b>10</b>	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>114,990,139.0</b>	<b>3,499,068.7</b>	<b>(72,604,968.0)</b>	<b>45,884,239.7</b>
<b>11</b>	<b>2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>114,990,139.0</b>	<b>3,499,068.7</b>	<b>(72,604,968.0)</b>	<b>45,884,239.7</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	114,990,139.0	3,499,068.7	(72,604,968.0)	45,884,239.7
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	22,075,311.8	22,075,311.8
<b>20</b>	<b>2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>114,990,139.0</b>	<b>3,499,068.7</b>	<b>(50,529,656.2)</b>	<b>67,959,551.5</b>



## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
				Дүн	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	192,613,100.0	191,476,922.2	1,136,177.8	99.4
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	192,613,100.0	191,476,922.2	1,136,177.8	99.4
210	Бараа, үйлчилгээний зардал	192,278,300.0	191,146,922.2	1,131,377.8	99.4
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>135,042,200.0</b>	<b>134,993,826.1</b>	<b>48,373.9</b>	<b>100.036</b>
210101	Үндсэн цалин	99,408,100.0	95,688,773.7	3,719,326.3	96.3
210102	Нэмэгдэл	29,463,400.0	26,418,506.1	3,044,893.9	89.7
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	4,358,000.0	6,410,000.0	(2,052,000.0)	147.1
210104	Урамшуулал	1,812,700.0	6,476,546.3	(4,663,846.3)	357.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,880,200.0	16,880,200.0	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	11,478,600.0	11,478,600.0	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,350,400.0	1,350,400.0	-	100.0
210203	ҮОМШӨ ний даатгал	1,080,300.0	1,080,300.0	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	270,100.0	270,100.0	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	2,700,800.0	2,700,800.0	-	100.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>19,661,400.0</b>	<b>18,949,478.1</b>	<b>711,921.9</b>	<b>96.4</b>
210301	Гэрэл цахилгаан	1,708,900.0	1,112,342.1	596,557.9	65.1
210302	Түлш, халаалт	8,495,200.0	8,448,126.0	47,074.0	99.4
210303	Цэвэр, бохир ус	1,057,300.0	989,010.0	68,290.0	93.5
210304	Байрны түрээс	8,400,000.0	8,400,000.0	-	100.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,360,000.0</b>	<b>7,265,900.0</b>	<b>94,100.0</b>	<b>98.7</b>
210401	Бичиг хэрэг	511,900.0	822,980.0	(311,080.0)	160.8
210402	Тээвэр (шатахуун)	3,455,800.0	3,455,200.0	600.0	100.0
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	2,383,300.0	2,072,220.0	311,080.0	86.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	242,700.0	149,200.0	93,500.0	61.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	766,300.0	766,300.0	-	100.0
2105	Нормативт зардал	776,600.0	776,600.0	-	100.0
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	776,600.0	776,600.0	-	100.0
2106	Эд хогшил худалдан авах	3,372,400.0	3,362,700.0	9,700.0	99.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,231,700.0	2,231,700.0	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	367,800.0	367,800.0	-	100.0
210604	Урсгал засвар	772,900.0	763,200.0	9,700.0	98.7
2107	Томилолт, зочны зардал	5,090,200.0	5,090,200.0	-	100.0
210702	Дотоод албан томилолт	5,090,200.0	5,090,200.0	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,561,300.0	1,312,568.0	248,732.0	84.1
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	48,000.0	-	48,000.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	75,200.0	49,500.0	25,700.0	65.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	222,000.0	68,068.0	153,932.0	30.7

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	24,000.0	22,000.0	2,000.0	91.7
210806	Мэдээллийн технологийн зардал	253,000.0	253,000.0		100.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	19,100.0	-	19,100.0	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	920,000.0	920,000.0		100.0
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	2,534,000.0	2,515,450.0	18,550.0	99.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	980,800.0	962,250.0	18,550.0	98.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,553,200.0	1,553,200.0	-	100.0
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	334,800.0	330,000.0	4,800.0	98.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	334,800.0	330,000.0	4,800.0	98.6
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	334,800.0	330,000.0	4,800.0	98.6
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>192,613,100.0</b>	<b>201,093,722.2</b>		<b>104.4</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>117,991,900.0</b>	<b>116,855,722.2</b>	<b>1,136,177.8</b>	<b>99.0</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	117,991,900.0	116,855,722.2	1,136,177.8	99.0
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>74,621,200.0</b>	<b>84,238,000.0</b>	<b>(9,616,800.0)</b>	<b>112.9</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	74,621,200.0	84,238,000.0	(9,616,800.0)	112.9


## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	4,100,000.0
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	4,100,000.0
210	Бараа, үйлчилгээний зардал	-	4,100,000.0
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,100,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,100,000.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>4,100,000.0</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	4,100,000.0
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,100,000.0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс /Цаашид Стандарт, хэмжил зүйн хэлтэс гэх/ нь 2022 оныг “Стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжил зүйн төрийн бодлогыг хэрэглэгчдийн сэтгэл ханамжид нийцүүлэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад хөнгөн шуурхай хүргэх” зорилгын дэвшүүлэн ажиллаж, баталгаажуулалтын үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа үзүүлж байна.



#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс даган мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд тус тус нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатны хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тус албаны санхүүгийн үйл ажиллагаанд Стандарт, хэмжил зүйн хэлтсийн “Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс”-ээс хяналт тавьж ажилладаг бөгөөд тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл

үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус хэлтэс нь Стандарт, хэмжил зүйн газраас 2020 онд гаргасан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23,602.3 мянган төгрөгөөр буюу 1.5 дахин өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	709.3	3,158.7	2,449.4
Бараа материал	9,632.7	10,112.1	479.4
Үндсэн хөрөнгө	35,542.2	56,215.7	20,673.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>45,884.2</b>	<b>69,486.6</b>	<b>23,602.3</b>
Өр төлбөр	-	1,527.0	1,527.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	45,884.2	67,959.6	22,075.3
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>45,884.2</b>	<b>69,486.6</b>	<b>23,602.3</b>

Авлага дансны үлдэгдэл 3,158.7 мянган төгрөг болж 2,449.4 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны авлагыг 709.3 мянган төгрөгийг барагдуулсан болон оны эцэст төрийн сангийн гүйлгээ хаагдсанаас хойш хийгдсэн баталгаажуулах үйлчилгээний төлбөрийн 3,158.7 мянган төгрөгийн авлага үүссэнээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 10,112.1 мянган төгрөг болж 479.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 10,033.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, Стандарт, хэмжил зүйн газраас 280.6 мянган төгрөгийн бараа

материал шилжүүлэн авсан болон 9,834.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл */анхны өртгөөр/* 78,126.3 мянган төгрөг болж 48,063.8 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 1,371.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж бэлтгэж, Стандарт хэмжил зүйн газрын даргын 2022 оны А/197 дугаар тушаалаар 16,463.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй шилжүүлэн авсан, ТӨБЗГ-ын 2022 оны 657 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглагдаж байгаа 13,600.1 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж данс бүртгэлд тусгасан болон 705 дугаар тогтоолыг үндэслэж 79,498.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг акталж, данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Өр төлбөрийн данс 1,527.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь бараа үйлчилгээний зардлын 360.0 мянган төгрөгийн, байгууллагад төлөх төлбөрийн 1,167.0 мянган төгрөгийн өр төлбөр шинээр үүсгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 67,959.6 мянган төгрөг болж 22,075.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, зарлагыг тус бүр 242,784.0 мянган төгрөгөөр тооцон улсын төсвөөс санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид санал хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт орлого, зардлыг 54,792.1 мянган төгрөгөөр бууруулж, 187,991.9 мянган төгрөгөөр */зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн орлогын 117,991.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 70,000.0 мянган төгрөгийг үйл ажиллагаанаас/* баталсан байна.

2022 оны төсвийн төслийн саналын урсгал үйл ажиллагааны зардлыг 54,792.1 мянган төгрөгөөр бууруулан баталсан нь 31,650.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардлаас, 5,019.0 мянган төгрөгийг томилолт, зочны зардлаас тус тус бууруулснаас голлон шалтгаалсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант оны батлагдсан төсвийг 4,621.1 мянган төгрөгөөр өсгөж 192,613.1 мянган төгрөг болгон төсвийн зохицуулалт хийсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 74,621.2 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос, 117,991.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр үйл

ажиллагааны орлогоос 74,621.2 мянган төгрөг, улсын төсвөөс 117,991.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Тайлант онд тус хэлтэс нь үйл ажиллагааны орлогын батлагдсан 74,621.9 мянган төгрөгийн төлөвлөгөөг 12.8 хувиар давуулан биелүүлж 84,238.7 мянган төгрөг төвлөрүүлсэн бөгөөд төлөвлөгөөнөөс давсан 9,616.8 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 191,476.9 мянган төгрөг буюу 99.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 1,136.2 мянган төгрөгөөр хэмнэж, хэмнэлтийг улсын төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	192,278.3	191,146.9	1,131.4	99.4
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	334.8	330.0	4.8	98.6
	Дүн	192,613.1	191,476.9	1,136.2	99.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус хэлтсийн нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс “Чанарыг эрхэмлэгч байгууллага”-д олгох шагналын санхүүжилтийн 4,100.0 мянган төгрөг шилжиж ирснийг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал,

дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн тус хэлтэст төсвийг зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар үнэн зөв үндэслэн төлөвлөж, хэрэгжүүлэхтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор 3.Золбоо гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 202,915.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 3,043.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Стандарт, хэмжил зүйн газраас “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах чиглэл”-ийг харьяа албадад өгч ажилласны дагуу сургалт, хурал зөвлөгөөнийг цахим хэлбэрт шилжүүлж холбогдон гарах зардлыг хэмнэсэн, мөн байгууллагын цахилгааны хэрэглээнд албан хаагчдыг хэмнэлттэй байх үүрэг даалгавар өгч, үр ашиггүй зардал гаргахгүй ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.


##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор



www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Стандарт, хэмжил зүйн хэлтэс нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 20 төрлийн 167 мэдээллээс 166 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн бол төсөв, өмч, хөрөнгө, захиран зарцуулах 1,512.6 мянган төгрөгийн 1 шийдвэрийг мэдээлээгүй байна.



Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй зэрэг 8,844.3 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт  
/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	8,844.3	2	8,844.3	100
Нийт дүн	2	8,844.3	2	8,844.3	100

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 2,807.2 мянган төгрөгийн 2 зөрчил<sup>1</sup> илэрснээс 1,527.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1,280.2 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгсөн.



### 5.1 Албан шаардлага

**1.1 Илрүүлэлт:** Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 1,527.0 мянган төгрөг / бараа үйлчилгээний зардлын 360.0 мянган төгрөгийн, улсын мэдээллийн маягт хэвлүүлсний болон бусад төлбөрийн 1,167.0 мянган төгрөг /-ийн өр төлбөр үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**1.2 Шийдвэрлэсэн нь:** Төсвийг зохистой удирдаж, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэв.

### 5.2 Зөвлөмж

#### 1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

**1.1 Илрүүлэлт:** Төсвийн төлөвлөлтийг бодит хэрэгцээ шаардлага, судалгаанд үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөж, хэрэгжүүлээгүйгээс томилолтын зардал 1,280.2 мянган төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас санхүүжүүлсэн байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2 дахь “Төсвийн иж бүрэн, **үнэн зөв** байдлыг хангасан байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:** Зардлыг бодит хэрэгцээ шаардлага, тооцоо судалгаан дээр үндэслэж, үнэн зөв төлөвлөж, хэрэгжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаал	Тоо	Дүн
Өр төлбөр үүсгэсэн	1	1,527.0			1	1,527.0						
Төсвийг бодитоор төлөвлөж, хэрэгжүүлээгүй	1	1,280.2					1	1,280.2				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>2,807.2</b>			<b>1</b>	<b>1,527.0</b>	<b>1</b>	<b>1,280.2</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Төсөв, өмч хөрөнгө захиран зарцуулах шийдвэрийг мэдээлээгүй	1	1,512.6						1	1,512.6
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1,512.6</b>						<b>1</b>	<b>1,512.6</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
<b>Дүн</b>									
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>1,512.6</b>						<b>1</b>	<b>1,512.6</b>



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 13/А1840390  
00А-2023/256 НАСТАГУС

Сүхбаатар

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 1,527.0 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: " 4.2.1.11: "Хууль тогтоомж, ... зөрчсөн ..." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас өр төлбөр үүсгэсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллаж,

018040037

биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

- Цаашид холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэлэнгэ аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга Д.Ган-отгон, нягтлан бодогч Ц.Уртнасан нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

З.ЗОЛБОО